

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/13ek-uf74-ka49

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVIII • 2025 • № 3

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,*
доктор филологических наук (Россия)

Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат*
филологических наук (Россия)

М. А. Козинцев, *помощник секретаря,*
кандидат исторических наук (Россия)

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*

А. Бирталан, *доктор наук (Венгрия)*

Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*

Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*

И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН*
(Россия)

Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*

В. Капишовска, *доктор наук (Чехия)*

Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук*
(Монголия)

С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*

К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*

М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*

Р. Поп, *доктор наук (Румыния)*

Ц. Саранцацрал, *доктор филологических наук*
(Монголия)

Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор*
(Россия)

С. Чулуун, *академик МАН (Монголия)*

Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*

Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*

Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 15.09.2025

Формат 60×90 1/8. Объем 7 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Литография».

Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8,
лит. А, офис 14.

e-mail: info@litobook.ru

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2025

© Коллектив авторов, 2025

В НОМЕРЕ:

ИСТОРИЯ

- С. Мөнхсайхан.** Чингисийн чулууны бичгийн түүхэн үндсийг
Монголын Нууц Товчооноос сурвалжлах нь 5

ФИЛОЛОГИЯ

- О. К. Баваева.** Целебный родник поэзии Николая Хатуева 14
- Ч. Заяасүрэн.** Тэмээний даллагын бичмэл хоёр судрын тухай 19
- Р. П. Сумба.** Рукописи и ксилографы на монгольском и тибетском языках
из фондов Национального Музея Тувы 30

ИЗ АРХИВОВ ВОСТОКОВЕДОВ

- С. С. Сабрукова.** Н. Э. Уланов (1867–1904) о подготовке экспедиции в Тибет
(по материалам АВ ИВР РАН) 37

НАУЧНАЯ ЖИЗНЬ

- А. А. Колесников, И. В. Кульганек.** Военное востоковедение на службе Отечеству.
К 80-летию Великой Победы (Санкт-Петербург, 23–24 июня 2025 года) 54
- Т. Д. Скрынникова.** [Рец. на]: Цендина А. Д. Жизнь, отраженная в текстах:
народная магия монголов (конец XVI — начало XX в.). Приметы, сонники,
гадательные книги, обереги, заклинания, моления.
М.: Изд. дом Высшей школы экономики, 2024. 536 с.
(Orientalia et Classica series. IX (LXXX))..... 60

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)



191181, Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18
Phone: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVIII • 2025 • No. 3

The journal is published four times a year.

Published since 1986

Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

- I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*
D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*
M. A. Kozintcev — *assistant secretary, Cand. Sci. (History), Russian Federation*
G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*
A. Birtalan. *Ph. D., Hungary*
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*
L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
J. Legrand. *Dr. Sci., Professor, France*
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*
E. E. Khabunova, *Dr. Sci. (Philology), Russian Federation*
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*
E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*
S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*
R. Pop. *Ph. D., Romania*
Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*
T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*
R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*
N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*
I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

IN THIS ISSUE:

HISTORY

- Serjee Munkhsaikhan.** Investigating the Historical Root of the Stele of Genghis Khan..... 5

PHILOLOGY

- Olga K. Bavaeva.** A Healing Spring of Poetry by Nikolay Khatuyev..... 14
- Chuluun Zayasüren.** Two of the Manuscript Sutra's for Camel "Dallaga" 19
- Rita P. Sumba.** Written Sources in Mongolian and Tibetan Language at the Collections
of the National Museum of the Republic of Tuva 30

ARCHIVES OF ORIENTAL STUDIES

- Svetlana S. Sabrukova.** Naran E. Ulanov (1867–1904) on Organizing an Expedition to Tibet in 1904
(From the Archives of Orientalists at the Institute of Oriental Manuscripts
of the Russian Academy of Sciences)..... 37

ACADEMIC LIFE

- Alexander A. Kolesnikov, Irina V. Kulganek.** Military Oriental Studies on the Service
of the Motherland: On the 80th Anniversary of the Great Victory (St. Petersburg, June 23–24, 2025)..... 54
- Tatiana D. Skrynnikova.** Review of the Book: Tsendina, Anna D. Life Reflected in Texts:
Folk Magic of the Mongols (Late 16th to Early 20th Centuries). Omens, dream books,
fortune-telling books, amulets, spells, and prayers. — Moscow: HSE Publishing House, 2024. —
536 p. — (Orientalia et Classica series. IX (LXXX))..... 60

Чулууны ЗАЯАСҮРЭН
Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

ТЭМЭЭНИЙ ДАЛЛАГЫН БИЧМЭЛ ХОЁР СУДРЫН ТУХАЙ

Өгүүлэлд бичгийн дурсгалаар уламжлагдан ирсэн тэмээний даллагын хоёр судрын агуулга, дүр дүрслэлийн онцлогийг тодруулан хооронд нь харьцуулав. Нүүдэлчин малчид хавар тэмээний даллагын шүлэг хэлж, буян хишиг хурайлан дууддаг байжээ. Тухайлбал, даллагын идээгээ хангай дэлхийдээ өргөж хурайлан, үүний хариуд хүссэн бүхэн нь биелэхийг ерөөдөг байсан байна. Тэмээний даллагын шүлгийн агуулга нь тахил өргөсний хариуг эргүүлж авах бэлгэдэлтэй, харилцан тэгш хэмтэй бүтээгдсэн, шүлгийн бүтэц, зохиомж болон шүлэглэл зүйн онцлогтой байна.

Түлхүүр үг: тэмээний даллага, галын тахилга, тэмээний домог, дүр дүрслэл, бүтэц зохиомжийн онцлог.

Зохиогчийн мэдээлэл: Чулууны ЗАЯАСҮРЭН, доктор (PhD), дэд профессор, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Аман зохиол судлалын салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан (Монгол Улс, Улаанбаатар) (zayasurench@mas.ac.mn).

© Заяасүрэн Ч., 2025

Монголчууд эртнээс таван хошуу мал төллөх, малын үс ноос авах, төл малаа хөнгөлж агтлах, цагаан идээний дээж дэлгэрч, сүү саалийн цаг эхлэх үед заавал ёсчлон гүйцэтгэдэг ардын зан үйлтэй, байгаль дэлхийгээ шүтэж, үгийн ид шидээр хайр өршөөл хүсэж гуйдаг уламжлалтай байжээ. Энэхүү ардын зан үйлийн нэгэн хэлбэр бол тэмээний буян хишиг дуудаж даллага авах ёслол юм.

Даллага гэдэг нь ямар нэгэн буян хишиг гуйх зан үйлийн нэр болно. Тэмээний даллага Монголын говь нутагт өргөн дэлгэрсэн, хавар ингэ ботголох үеэр тэмээгээ гэрийнхээ гадаа авчирч, ингээ сааж сүүг нь хөөрүүлээд буур болон бусад бүх тэмээндээ сан тавьж, тэмээний даллагын судрыг тусгай мэргэшсэн хүнээр уншуулж, ингэнийхээ сүүг ууж ёсолдог тэмээн сүргийн үржлийг бэлгэддэг томоохон баяр [Жамбалдорж, 2019] байв.

Өнөө цагт бичгийн дурсгалаар тэмээний даллагын хоёр судар уламжлагдан ирсний нэг нь нэлээд сонирхолтой, эртний өнгө

аястай “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив” болно.

Уг сударт галын тэнгэрийн дүрийг дүрсэлсэн нь: “*Хоосны агаараас ламаас шар алтан дэлхийн дээрд улаан Рам үсэг огоот болсноос Галын тэнгэр биеийн өнгө улаан нэгэн нүүртэй, хоёр мутартай, хүрэн улаан сэрхэн ямаа хөлөглөсөн баруун мутраар тоолохуй эрх барьсан зүүн мутраар галын дэвүүр барьсан биедээ элдэв зүйл хивээр чимсэн галын тэнгэр нөхрийн чуулганаар хүрээлүүлж өмнийн огторгуйд заларч ирэв*” [МСМҮД, 2021. Х. 104] гэж галын тэнгэр хэрхэн ямар дүртэй заларч ирснийг тодорхой дүрсэлжээ.

Галын бурхан бол зүүн урд зүгт оршдог гэж үздэг. Тухайн сударт “*Рам үсгээс үүдсэн Аршсын увдисаар бүтсэн*” гэсэн дүрслэл тохиолдож байгаа боловч тэмээний нөгөө нэг “Тэмээний даллагын судар”-т байхгүй байна.

“*Сударт ертөнцийн итгэл эрхт баялаг эсрүүний эрхтийн хөвгүүн тэнгэрийн хаан аршийн ёсныг баригч Дээд бэлгэ бэлгээр хамаг*

нисваанисыг түлэгч Галын тэнгэр тийн нигүүлсэгчид сөгдмүй” [МСМУД, 2021. Х. 104]. Ийнхүү өглөгийн эзэн өөх тос зэрэг галын дөлийг амархан бадраах зүйлсийг галдаа өргөж галаа түлж, хүслээ даатган залбирахдаа:

“Егүзэр миний нөхөр сэлтэд
Өвчин үгүй насан хийгээд эрхт баялаг ба
Цог төгссөн алдар лүгээ сайн хувь
Ахуй их төгс эдлэл бүгдийг олгоод
Амарлингуй хийгээд дэлгэрэн үгүй тэргүүт-
ний
Үйлсийн шидийг надад өгөн соёрх
Тангарагтан бээр амийг сахигтун
Шид бүхэн бээр нөхцөн зохио...” [МСМУД, 2021. Х. 104]

хэмээсэн нь хүн болгонд цаг бусын өвчин зовлон, саад тотгор, муу ёрын зүүд зэрэг үгүй болж, эд баялаг тогтож, санасан бүхэн бүтэхийг хүссэн санаагаа илэрхийлжээ.

“Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”, “Тэмээний даллагын судар”-т Лам Егүзэрийн номлосон гэж гарч байгаа нь тарнийн номд мэргэшсэн лам хүн айлджээ.

Гал тахих зан үйл: Эртнээс айл гэр бүл бүр гал голомтоо эрхэмлэн дээдэлж, түүнийгээ цэвэр ариун авч явах нь хүн бүрийн эрхэм үүрэг төдийгүй гал голомтоо хүндэтгэн дээдэлж цэвэр ариун авч явбал аз жаргалтай, сайн сайхан амьдардаг гэж өвөг дээдэс бидэнд заан сургаж ирсэн билээ. Энэ нь эртний монгол гэрийн ёсонд гал голомтоо хүндэтгэх, шаардлагатай тохиолдолд галаа тахих, идээний дээжээ өргөх, гал руугаа бохир зүйл хийхгүй ариун байлгахыг чухалчилсаар ирсэн.

Дээрх харьцууллаас харахад “Тэмээний даллагын судар”-т тухайн зан үйлд ашиглах эд зүйлийг маш нарийн зааж өгчээ. “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”-д: Бэлдсэн


эд зүйлсийг ёс жаягаар нь дараалуулан өргөж, ёсчлон гүйцэтгэж байгаа нь тэгш дүүрэн байхын бэлгэдэл утгыг илэрхийлсэн байна.

Гал тахих зан үйлийн дэс дарааллыг тоочихдоо “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”-д “Зээрийн өвчүүгээр галын тэнгэрийг тахихыг хүсэгч бодгаль бээр Найман гэгээн Даишдондов эднийг уншиж, тулганы доторхыг сайтар арчин цардаад найман навчтай лянхуа зурж хүйлсэнд гурил буюу зээрний өөхөөр Сэрхэн ямаа үес гишүүн бүрэн босоо нэгнийг үйлдээд улаан бударганаар дөрвөлжин хэлбэрээр жигдлүүлж зэрэглээд түүний дээр шаргачин зээрийн өвчүүнийг өнгийн торго магнагаар чимээд улаан хар бударганыг тэмээний унгасаар (ноос) ороож бас элдэв зүйл тариа гурван зүйл амттаныг дотор нь хийгээд, галд оршуулж гал оруулаад, дэвүүрээр дэвж галыг бадруул” [МСМУД, 2021. Х. 105] гэж маш тодорхой дүрсэлж өгчээ.

Найман гэгээн нь бурхан багшийн айлдсан заслын ном бөгөөд тахилга болох өдрийн саад тотгорыг арилгадаг гэж үздэг. Зуухан дотор найман лянхуа дэлбээтэй цэцэг зурдаг нь бурхны шашны бурхдыг, лянхуа цэцгэн дээр заларч байгаагаар дүрсэлдэг нь галын бурхныг энэхүү цэцгэн дээр залрахыг бэлгэдэж хийдэг. Гал махбодын өнгө нь улаан байдаг учраас улаан бударганаар бэлгэдэн галыг тахидаг. Мөн тэмээний унгасаар элдэв зүйл тариа, гурван зүйл амттаныг боож галд өргөдөг нь тэмээний буян хишгийг бэлгэдэн галын бурхандаа тэмээний унгасаар хувцас болгон бэлгэдэж өргөдөг ёстой. Уг сударт:

“...Хатан болд төмөр эцэгт
Суут богдын цахисан
Сутай хатныг үлээсэн
Гоман нэрт өвгөний цахисан
Гама нэрт эмгэний үлээсэн
Богд Чингис хааныг хүүхэд ахуйгаас

“Тэмээний даллагын судар”-т:	“Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”-д:
6 зул, 6 хүж, 4 тарианы үр, 3 амттан, зээрийн өвчүүнүүдийг хийж тахигдах болой...” [МСМУД, 2021. Х. 116]	4 зул, 4 хүж, 4 цөгцөнд 4 хэсэг мах тавиад, хишиг далла, Ум аа хум-ыг гурвантаа өгүүл!..” [МСМУД, 2021. Х. 105]



Зураг 1. “blam-a yogajari-yin nomlaysan: yal-un tngri-yi takiyad: temegen-ü buyan kesig abqui yosun orosiba” (26)

Ботгон тэмээний төрөхүй ахуйгаас
Хатан эхийн салчиг ахуйгаас
Хар тэмээн төрөхүй ахуйгаас
Хайлаасан модны найлзуур ахуйгаас...”
[МСМУД, 2021. Х. 105]

гэж галын дөлийг хэрхэн бадраасан тухай өгүүлжээ. Энэ нь өнөөгийн хуримын ёсонд ч өрхийн тэргүүн хэтээ цахиж, эхнэр нь галаа үлээн бадрааж асаадаг ёс уламжлагдсан хэвээрээ байгааг өгүүлжээ. “Чингис хааныг бага балчир ахуйгаас” гэж буй нь эрт үеэс улбаатай болохыг харуулж байна. “Монголчуудын уламжлалт сэтгэлгээнд галыг ертөнцийн хэлбэрээр нь амьдчилан үзэж, бурханчлан шүтдэг” [Бямбадорж, 2002. Х. 122] байсны илрэл мөн. Энэ тухай,

“...Шар тосон идэшт
Цагаан зээрний өвчүүн тахилгат
Этүгэн эх нэвт илчит,
Тойром нүүрт тосон идэшт,

Зэрлэг гөрөөсний өвчүүн тахилгат,
Өөхөн тосыг өргөн суунам!
Өөхөн тосыг өргөн суунам!
Урт хөлт тэмээний буян хишиг ирэн заяан атугай!


Хайр си чулуу эхт, хатан болд төмөр эцэгт,
Отчан галаахан, галын тэнгэр мираза-д...”
[МСМУД, 2021. Х. 106–107]

гэхчлэн хүн байгалийн хүйн холбоог тодорхой дүрсэлж өгчээ.

Тэмээтэй холбогдох домог: “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив” сударт тэмээтэй холбоотой сонирхолтой домог уламжлагджээ. “Эрт урьд сав шим бүтэхүүд төвөдийн оронд газрын уул мэт хэлбэртэй тэмээн хэмээх амьтан наян нэгэн муу ёртой, найман өлзийтэй явсан ажгуу! Тэр цагт Тангуд улс ачиж унаад зарж эдэлж явтал нэгэн цагт тэмээн үхвээс зүүн хойд зүгт хандаж үхэх, харж явах хэвтэх, хархирваас

сэвс нь хүний биед хурвээс яр шарх гарах болсон учирт Тангуд улс бүгдээр цуглаж: “Энэ тэмээдийг үлдэж орхихоос бус арга үгүй” хэмээн зөвлөн хэлэлцэж, их гүрмийг уншуулж хариулга хийлгэж үлдэж орхихуйдаа “Тэмээд хаана тогтсон орон газартаа өлзийтэй болтугай” хэмээн ерөөл тавьснаар монголын газарт ирж тогтсон тул монгол хүнд ихэд өлзийтэй болсон учир шалтгаан тэр болой! Бие дээл хувцсанд тэмээний сэвс хурвээс нойтонд үл арилгах болоод аливаа аян ав цэрэгт аялан явахуйд ачаанаас хойно дагаж мордох ёсны учир үлгэр энэ бөлгөө!” [МСМҮД, 2021. Х. 105] гэж домогложээ. Үүнтэй төстэй өөр нэгэн домгийн хувилбарыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гэлэгийн Дашзав мэдээлжээ. “Тэмээг анх Энэтхэгийн орноос Монгол оронд хараал хий гэж явуулсан байна. Монгол оронд ирээд явж байгаад эмэгтэй хүнтэй тааралдахад

нь тэр эмэгтэй баганаа аваад хамарт нь хатгаад буйлласан гэдэг домогтой. Тэгээд тэр буйлаар нь номхотгосон” [МАБӨА, 2020. Х. 357] тухай өгүүлдэг. Энэ хоёр домгийн агуулгыг харьцуулахад тэмээг Энэтхэг, Тангудын орноос ирсэн гэх өгүүлэмж нь ижил боловч эхний домогт Тангуудын газар нутаг тэмээнд тохиромжгүй тул түүнд хамгийн тохиромжтой нь монголын газар нутаг байсан учраас тухайн нутагт нь ирүүлсэн тухай өгүүлдэг бол хоёр дахь домогт монголчуудад хараал хийлгэхээр явуулж, ирсэн даруйд уг тэмээг номхотгон буйллаж өдөр тутмын ачлага, уналгад хэрэглэх болсон ажээ. Ерөнхийдөө энэ 2 домгийн ерөнхий агуулга, зохиомж төстэй боловч бага зэргийн ялгаатай байна. Жишээлбэл, эхний домогт газрын үүл мэт хэлбэртэй тэмээн хэмээх амьтан хэмээн дүрсэлсэн нь эртнээс монгол хүн тэмээг тэнгэрийн амьтан гэж шүтэж




Зураг 2. “blam-a yogajari-yin nomlaysan: yal-un tngri-yi takiyad: temegen-ü buyan kesig abqui yosun orosiba” (4a)

дээдэлж байсны улбаа мөртэй холбоотой ч байж болох юм [Жамбалдорж, 2019. Х. 31] гэсэн байдаг. Дээрх хоёр судрын “бүтэц зохиомж, дүр дүрслэл, өгүүлэмжид энэтхэг, төвөдийн буддын шашны ертөнцийг үзэх үзлийн ойлголтууд орсныг ажиглаж болохоор байна. Энэ нь монголд бурхны шашны дэлгэрэлттэй, нөгөө талаар өнө эртний болон хожуу үеийн түүхэн цаг үе үйл явдалтай [Бямбадорж, 2002. Х. 122] холбоотой болов уу.

Тэмээний даллагын судар “ум сайн амгалан болтугай” гэх ерөөлийн үгээр хамгийн түрүүнд эхэлдэг нь “бурхны шашны уламжлалд буй алив сан судар зохиох унших, зан үйл үйлдэхийн өмнө лам гурван эрдэнэ (dkon mchig gsum) буюу Бурхан багш (sans rgyas), ном (G cos), хувраг (dge dun) нарт итгэл явуулдаг, ямар нэг бурхан бодисад болов хэмээн бясалгах ёстой холбоотой” [Бямбадорж, 2002] ажээ. Тухайн сударт бас нэгэн сонирхолтой дүрслэл байгаа нь “арван хоёр жил бүрдсэн” хэмээсэн нь

тэмээ бол арван хоёр жилд багтаагүй ч 12 жилд багтсан бүх амьтны шинжийг биедээ шингээсэн амьтан. Тухайлбал, тэмээг хулгана чихтэй, үхэр гэдэстэй, бар тавагтай, туулай хамартай, луу биетэй, могой нүдтэй, морин дэлтэй, хонин ноостой, мичин бөхтэй, тахиа өрөвлөгтэй, нохой гуятай, гахайн сүүлтэй төстэй байгааг нүүдэлч малчид маш сайн ажиглаж, харьцуулж мэдсэнтэй холбоотой.

Шувуу халуун орноос урт холын аян зам туулж нисэн ирэх, мөн буцах үеэр тэнгэр, газар, ус хямарч цаг агаарын байдал гэнэт хувирах үзэгдлийг халхад шувууны зад, буриадад галууны зад, шувууны болзор, цагаан шувуунай зада, ойрадад шувуунаа зад, шувуунаа зуд гэж нэрлэдэг. Энэхүү байгаль цаг уурын хариулга болгож шувууны даллагын ерөөл авхуулдаг уламжлал нүүдэлчин малчдын дунд үүссэн бололтой. Иймээс шувууны зад, шувууны зудын үеэр цаг агаарын хүнд хатуу үеэс нялх төл, малын хишиг буяныг тэнгэр, газар,



Зураг 3. “blam-a yogajari-yin nomlaysan: yal-un tngri-yi takiyad: temegen-ü buyan kesig abqui yosun orosiba” (46)

уул усны эзэн савдагт хүсэмжлэн гуйж даллагын ерөөл уншуулж сан байжээ [Цолоо, 1998. 09.12]. Энэ тухай шувууны даллагын сударт: “хулгайч хүний хусан уурга хугартугай, хун цагаан шувуу адгуусан чинь энх мэнд хонотугай, өшөөт хүний өргөсөн уурга хугартугай, өглөө бүр өндгөн цагаан адгуусан энх мэнд хонотугай, буруу санаат хүний бургасан уурга хугартугай” [Чойжилсүрэн, 1964. Х. 210] хэмээн мал сүргээ цаг агаарын хүн хэцүү ган зуд, малын хулгайч дээрэмчин, болон чоно нохойн аюулаас хамгаалах дом, хариулга даллагын ерөөл уншуулдаг байсан монголчуудын эртний тогтсон уламжлалт ёс заншлын нэгэн баримт болон үлджээ. Өнөө цагт шувуу, тэмээний даллага хэн хэрхэн, аль нутагт яаж хийж байсан тухай мэдээ баримтыг мэдэх настай хүн бараг байхгүй болсон.

Тэмээний даллага авах хугацааг “цагаан цэн шувуу ирэхүйд, цаст уул гэсэхүйд, цагагч ингэ, цагаан шарагч ингэ ботголохүйд цаглашгүй их буянт даллага авнам хурай, хурай, хурай” хэмээн дуудаж тодорхойлдог байсан ажээ. Эрт дээр үеэс монголчууд хаврын даллага авхуулахдаа хун шувуун ирэхүйд, хур цасан гэсэхүйд хуагчин ингэ ботголохүйд, хутагт их даллага авнам хурай, хурай, хурай, ангир шувуун ирэхүйд, атар газрын ногоо ургахүйд, атигар хар ингэ ботголохүйд, алдалгүй ашдын их даллага авнам хурай, хурай, хурай, нугасан шувуун ирэхүйд нуур усан гэсэхүйд нармай олон их тэмээний буян хишиг гуйнам хурай, хурай, хурай!...” [МСМҮД, 2021. Х. 113] гэж тэмээний буян хишиг дуудаж цаг хугацааг хурайлан дуудсан шүлэг эхэлж уншаад сан тавьдаг. Энд “цагаан зүсмээр даллан эхэлж байгаа нь мал сүргийн эх дээж, эх түрүүг тэмдэглэдэг нэгэн зүйл бэлгэдэл утгатай, мал сүргийн өсөж үржихүйн бэлгэдэл болгодог” [Дулам, Нандинбилиг, 2022. Х. 107] байсан ажээ. Монголчууд эртнээс тэнгэрийн шувууг эрхэмлэн дээдэлж

ирсэн нь тусгалаа олсон байна. Тухайн тэмээний даллагын судрын өгүүлэмжид хаврын хүнд хэцүү гурван сарыг эсэн мэнд давж урин дулаан цаг ирэхийн бэлгэдэл газрын үржил шим, төл малын хорогдолгүй, мал сүргээ өсгөж олон болгохын хүсэж буян хишиг урин дуудаж далладаг. Бадаг бүрийн төгсгөл болгонд хурай, хурай, хурай гэх хэллэгийг гурван удаа давтаж хэлдэг. Энэ нь хүссэн ёсоор буян хишиг хурж тогтохын бэлгэдэл утгыг илэрхийлсэн зан үйлийн нэг хэлбэр юм.

Эрт үед баяд ноёд болон хөрөнгө чинээтэй олон тэмээтэй айл өрх хавар ингээ ботголоход тэмээний даллага авдаг байсан болов уу гэмээр дүрслэл “Тэмээний даллагын судар”-ын өгүүлэмжид тохиолдож байна. Жишээлбэл,

“...Ноёд баядын тэмээ ботголохуйд Номын их даллага авнам...” [МСМҮД, 2021. Х. 113] гэснээс тодорхой харж болохоор байна.

Хоёр судрын агуулгад ямар ямар шувууд дүрслэгдсэн байгааг хүснэгтээс харвал,

Дээрх харьцууллаас харахад, “Тэмээний даллагын судар”-т ердөө 4 шувуу, “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”-д 10 төрлийн шувууг тус бүр дүрслэгджээ. Эдгээр нь малчин хүнд өдөр бүр таардаг, тэдний сэтгэл санааг сэргээж, хөгжөөж баясгаж, хань бараа болдог үзэсгэлэнт шувууд юм.

“Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив” хэмээх судрын дүрслэлд говьд ургадаг хайлаас, бургас, тавалгана гэсэн гурван модны тухай дурдсан бол “Тэмээний даллагын судар”-т модны тухай огт дурдаагүй бөгөөд харин тэмээний иддэг голлох ургамал бударгана, багалуурыг дурдсанаараа ялгаатай болжээ. Энэхүү хоёр ургамал нь Монголын говь нутагт элбэг ургадаг бөгөөд тэмээ өвөл, хаврын улиралд амтархан иддэг.

“Тэмээний даллагын судар”-т	“Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”
Цагаан цэн шувуу, Хун шувуу, Ангир шувуу, Нугасан шувуун...” [МСМҮД, 2021. Х. 112–113]	Цагаан цэн шувуу, Хун шувуу, Ангир шувуу, Нугасан шувуу, Өрөвтас шувуу, Шар шувуу, Бүргэд шувуу, Тогоруу шувуу, Өвөөлжин шувуу, Хар галуу шувуу...” [МСМҮД, 2021. Х. 107–108]

“Тэмээний даллагын судар”-т: дөрвөн зүгээс буян хишгийг “...Баруун этгээдийн бэр төлгөний газраас амин насны хутгийг гуйнам, Хурай, хурай, хурай, Зүүн этгээдийн өр цагаан адгуусны өлзий хутгийг гуйнам, Хурай, хурай, хурай, Өмнө этгээдийн далай тайван хааны газраас алтан мөнгөн эд агуурсны хутгийг гуйнам, Өрнө этгээдийн Балбын газраас хонины буян хишгийн хутгийг гуйнам, Хурай, хурай, хурай...” [МСМУД, 2021. Х. 116] гэхчлэн хичээнгүйлэн гуйжээ.

Тэгвэл, “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”-д: “Умар этгээд зүгийн хувьд найман залуу охин тэнгэр бөлгөө, маш их хурьцалтай охин тэнгэр хийгээд, суунида охин тэнгэр ба, газар хийгээд, түүнчлэн лянхуа их хаанаа чухал агч ба, эгээрэлтэй хийгээд, язгуурт цогтой ба, тэдгээр тэмээн малд өвчин үгүй болоод өлзий хутаг орших болтугай...” [МСМУД, 2021. Х. 109] гэхчлэн өгүүлдэг нь ардын шүтлэг, бөө мөргөлийн нэгэн зүйл үзэл бөгөөд эрлэгийн эзний оршдог зүг учраас элдэв дайсан мангас, өвчин ад тэндээс ирдэг гэсэн [Дулам, 2020. Х. 159]

үг ажээ. Бас сударт өгүүлснээс харвал тэмээ малдаа элдэв өвчин тахал тусахгүй байхыг хан мөнх тэнгэр, хамаг бүгдэд даатган залбирал үйлдэхээс гадна засал хийдэг ардын тогтсон уламжлалт нэг арга байжээ. Дээрх дүрслэлд монголчуудын зүг чиг эрхэмлэх үзэл хэрхэн тусгалаа олсныг харж болно.

Сударт тэмээн сүргээ гаднын ямар нэгэн халдлага, хорлол тусахгүй байхыг илэрхийлэхдээ,

Найман хот шилтгээн эрхтэн сэлт найман тэнгэр нар нугууд тэдгээр тэмээнийг хотлоос сахитугай


Тэмээнийг явахад бээр өлзий хутаг орштугай

Бэлчиж яваад харьж ирэхүйд өлзий хутаг орштугай...

...Зуун намрыг олж үзээд ахуй их тэмээний сүргийн дотор сүр жавхлан ихэд

Тэмээний амин насан мандуулахын өлзий хутаг орших болтугай...” [МСМУД, 2021. Х. 109] гэхчлэн тодорхой дүрсэлжээ.

Бүтэц зохиомжийн онцлог: Тэмээний даллагын судрын бүтэц, зохиомжийн онцлогийг



Зураг 4. “Temegen-ü dalaly-a-yin sudar” (5a-6)

ажиглахад хөх мөнх тэнгэр, хөрст алтан дэлхий, этүгэн эх газар, уул усны эзэн савдгуудад тэмээн сүргээ даатгаж, буян хишиг урин дуудаж хурайлсан үгээр төгсгөсөн байдаг. Энэхүү бүтэц, зохиомжийн онцлогийг дээр дурдсан тэмээний даллагын хоёр судрын дүр дүрслэлээс тодруулав.

Тэмээний даллагын судрын бүтэц зохиомжийн дараалал нь *тахил-өргөл, өчил-хүсэлт* гэсэн үндсэн хэсгээс бүрдэл болж байна.

Тахил өргөлийн хэсэг: “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив”, “Тэмээний даллагын судар”-т: хэрхэн юугаар тахиж өргөснийг тодруулбал, “...Өөхөн тосон чинь өргөн суунам... цагаан зээрний өвчүүгээр тахинам, хуа зээрний өвчүүгээр тахинам, ахуй зээрний өвчүүгээр тахинам...” [МСМУД, 2021. Х. 106–107] гэж 2 зүйлээр тахил өргөлөө өргөсөн нь ижилхэн байна.

Өчил-хүслийн хэсэг: Энэ нь тэмээний даллагын сударт хамгийн түгээмэл хэрэглэгддэг хэсэг юм. Дээр дурдсан хоёр бичвэрт хураангуй болон дэлгэрэнгүй гэсэн хэлбэрээр өчиг хүслээ илэрхийлжээ. Жишээлбэл, “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив” гэх бичвэрт дурдагдсан “үйлсийн шидийг өгөн соёрх”, “өглөгийн эзэн үүнд өгөн соёрх”, “хоцрол үгүй бүгдийг өгөн соёрх”, “хүссэн шидийг сайтар өгөн соёрх”, “хоцрол үгүй бүгдийг хүлцэн соёрх”, “үйл юун үйлдсэн тэдгээр бүгдийг хүлцэн соёрх” гэж 6 удаа соёрхсон бол “тэмээний буян хишиг гуйнам”, “бууран тэмээний буян хишиг гуйнам”, бурантаг ихт тэмээний буян хишиг гуйнам” хэмээн тэмээний буян хишигийг 3 удаа хүсэн гуйжээ. Мал, эд зүйл, ном, арвай буудайг ирүүлэхийг хүссэн санаагаа “малын хишиг иртүгэй”, “цог залийн хишиг иртүгэй”, “хүний тусын хишиг иртүгэй”, “найман их лусын баялгийн хишиг иртүгэй”, “энэтхэгийн орноос номын хишиг иртүгэй”, “хар хятадын орноос төр ёсны хишиг иртүгэй”, “барс ирвэсийн хааны орноос малын хишиг иртүгэй”, “Балбын орноос алтны хишиг иртүгэй”, “төвөдийн орноос арвайн хишиг иртүгэй”, “Гэсэрийн орноос баатруудын хишиг иртүгэй”, “гүрү-гийн орноос адуу малын хишиг иртүгэй”, “сүмбийн

орноос үхрийн хишиг иртүгэй”, “хар тэргүүт хүний хишиг иртүгэй”, “алт мөнгөн ембүү бээр надад иртүгэй”, “үзэсгэлэн хувцасны хишиг надад иртүгэй”, “хишгийн гэр үүнд хишиг иртүгэй”, “хишиг наран саран мэт ургасаар өөд болж иртүгэй”, “гүйх одон мэт ярласаар өөд болж иртүгэй”, “үүлсийн цогц мэт бүрхсээр өөд болж иртүгэй”, “тавилгана мод мэт мушгиралдсаар өөд болж иртүгэй”, “солонго мэт дурдсаар өөд болж иртүгэй”, “сүмбэр уул мэт батадсаар өөд болж иртүгэй”, “сүн далай мэт ойлсоор өөд болж иртүгэй”, “усан мөрөн мэт буусаар өөд болж иртүгэй”, “түрвэл үгүй түргэн өөд болж иртүгэй”, “өлзий хутгийн буян хишиг надад иртүгэй”, “хүн эдийн буян хишиг надад иртүгэй” гэх зэргээр 27 удаа илэрхийлжээ. Мөн “өлзий хутгаар сахих болтугай”, “өлзий хутаг орших болтугай”, “тэмээнд өвчин үгүй болгоод өлзий хутаг орших болтугай”, “таны хилэн хорлол бүү болтугай”, “эд мал олоод үл барагдах болтугай”, “хутаг рашааныг олох болтугай”, “тэмээний насан мандуулахын өлзий хутаг орших болтугай”, “өглөгийн эзэн үүний хишигт өөд болтугай”, “эдийг арвитгагч хишиг тасрах үгүй болтугай”, “тусыг зохиогоод тэнгэрийн өлзий хутаг орших болтугай”, “урт наслаад өвчин үгүй амгалан жаргалан төгсөх болтугай” гэхчлэн аливаа өвчин, гаднын саад бэрхшээл, эд мал барагдахгүй байх, элдэв муу шалтгааныг дарах, буян хишиг арвидахыг хүссэн санаагаа 11 удаа тус бүр илэрхийлжээ. Мөн сударт тэмээнд ямар нэгэн саад тогтор тохиолдохгүй байхыг “тэмээнийг явахад бээр өлзий хутаг орштугай”, “бэлчиж яваад харьж ирэхүйд өлзий хутаг орштугай”, “садад таныг бээр үзэхүй өлзий хутаг орштугай”, “язгуурын үндсэн лам нугуудын өлзий хутаг орштугай”, “ядам бурхны чуулган нугуудын өлзий хутаг орштугай”, “эх дагинас нугуудын өлзий хутаг орштугай”, “номын сахиулсан нугуудын өлзий хутаг орштугай”, “орны тэнгэр дэлхийн эзэд нугуудын өлзий хутаг орштугай”, “юу санасан хэрэг бүгд бүтэхийн өлзий хутаг орштугай”, “эндүүрэл үгүй өөсөн бүтсэн биеийн өлзий хутаг орштугай”, “жаран гишүүт зарлигийн өлзий хутаг орштугай”, “хязгаарлалаас хагацсан хир үгүй сэтгэлийн өлзий хутаг орштугай”, “бурхан багшийн бие зарлиг сэтгэлийн өлзий хутаг орштугай”, “авралын

орон гурван эрдэнийн өлзий хутаг орштугай” хэмээн 13 удаа тус бүр илэрхийлжээ. Эдгээр нь аливаад амар амгалан тайван байхыг хүссэн санаагаа олон өнгө аясаар өөрсдийнхөө буян хишгээ даллаж, хурайлан гуйсан зүйлээ илэрхийлсэн нь нүүдэлчин малчдын өдөр тутмын аж амьдралын хэв маяг тэмээн даллагын судрын бүтэц, зохиомжид хадгалагдсан гэсэн үг.

“Тэмээний даллагын судар”-т: энэ тухай “цаглашгүй их буянт даллага авнам”, “хутагт их даллага авнам”, “алдал үгүй ашдын их даллага авнам”, “номын хишиг авнам”, “сүүн их даллага авнам”, “буян хишиг даллага авнам” гэж 6 удаа илэрхийлжээ. Мөн “буян хишиг нь иртүгэй”, “буян хишиг энд иртүгэй” гэж 2 удаа илэрхийлсэн бол “буян хишиг энд ирэн орштугай” гэх үгээр 6 удаа давтаж хэлсэн байна. буян хишиг гуйж хүссэн санаагаа сударт илэрхийлэхдээ “баруун этгээдээс гуйнам”, “зүүн этгээдээс гуйнам”, “бодисун хутгийг гуйнам”, “долоон өвгөн нэрт одноос хутгийг гуйнам”, “төлөгний газраас амин насны хутгийг гуйнам”, “өр цагаан адгуусны өлзий хутгийг гуйнам”, “алтан мөнгөн эд агуурсны хутгийг гуйнам”, “Балбын газраас хонины хутгийг гуйнам”, “төвөд ерөөлийн газраас үхрийн хутгийг гуйнам”, “эрдэнэ хулганын амнаас буух эрдэнийн сангийн буян хишиг хутгийг чинь гуйнам” гэж 10 удаа өгүүлснийг тус тус 2 сударт дуртган өгүүлжээ. Үүнээс харвал малчин хүний өдөр тутмын хэрэгцээг даллан дуудсан шүлэглэл нь бичгийн хэлбэрээр уламжлан хөгжиж ирэхдээ бөө мөргөл, бурхны шашны болон дорно дахины соёлын нөлөөг тусган баяжиж ирэхийн зэрэгцээ тахил-өргөл, хүсэлт-гуйлт гэсэн бүтэц, зохиомжийн үндсэн хэсгийг бүрдүүлсэн байна.

Нүүдэлчин малчид тэмээний даллагын шүлэг хэлж, буян хишиг хурайлан даллах бүрдээ даллагын идээгээ хангай дэлхийдээ өргөж хурайлан хүссэн бүхэн нь биелэхийг ерөөн бэлгэджээ. Шүлгийн бүтэц, зохиомжийг нэгтгэх юм бол тахил өргөсний хариуд нь эргүүлээд хурайлан даллаж авна гэсэн харилцан тэгш хэмтэй бүтээгджээ. Энэ нь нүүдэлчин малчдын өдөр тутмын ахуй амьдралын хэрэгцээнд суурилан үүссэн бөгөөд монгол хүний сэтгэл-

гээний онцлогийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэн уламжлагджээ.

Уг хоёр судрыг шүлэглэл зүйн талаас нь ажиглахад “Тэмээний даллагын судар” нь эхнээсээ төгсгөлөө хүртэл шүлэглэсэн хэлбэрээр зохиогдсон бөгөөд сүүл толгойг дээд зэргээр холбосон байдаг бол “Лам Егүзэрийн номлосон, галын тэнгэрийг тахиад тэмээний буян хишиг авахуй ёсон оршив” хэмээх судар нь эхэндээ үргэлжилсэн үгийн хэлбэрээр зохиогдож, сүүл рүүгээ шүлэглэсэн хэлбэрээр бичигдэхдээ мөн л сүүл толгойг холбож бичсэн байна.

ДҮГНЭЛТ

Орчин үед тэмээний даллага авах уламжлалт ёс заншлыг хэрхэн яаж гүйцэтгэж байсан тухай мэддэг настай хүмүүс байхгүй болжээ. Энэ нь нийгэм цаг үеийн хөгжил, иргэншлийн байдлаас хамааран хүмүүсийн ой тооноос мартагдсан гэсэн үг.

Энэхүү бичгийн хоёр дурсгалын дүр дүрслэлээс харахад монголчууд хаврын гурван сарыг даван гарч, урин дулаан цагийг угтахын бэлгэдэл болсон үржил шим, эх мал, төл малын хорогдолгүй, тоо толгой нь бүрэн бойжихын хишиг буяныг урин дуудсан утга нь нүүдэлчин малчдын оюун санааны ертөнцөд байгалийг үзэх үзэл, зөв зохистой харилцаа, төсөөлөл чухал байр эзэлж ирсний илэрхийлэл юм.

Идээ цагаа элбэгшин хүн малын сэтгэл санаа тэнгэр байж, урин дулаан зуны улиралд өнтэй сайхан зуншихыг бэлгэдэж хөх мөнх тэнгэр, хөрст алтан дэлхий, уул усны эзэнд хүсэмжлэн даатгаснаар элбэг дэлбэг, сайн сайхан амьдарна гэсэн чин хүсэл мөрөөдөл үе үеийн монгол хүний оюун санаанд байсаар ирсний баталгаа юм. Монголчуудын аливаад итгэл үнэмшил, сүсэг бишрэлээр ханддаг сэтгэлгээний өвөрмөц энэ онцлог өнөөгийн даяаршлын эрин зуунд ч хадгалагдсан хэвээр байгаа.

Тэмээний даллага авах ёс нь уламжлагдан ирэхдээ бөө мөргөл, бурхны шашны болон дорно дахины соёлын нөлөөг шингээж, дүр дүрслэлээ баяжуулж ирэхийн зэрэгцээ тахил-өргөл, хүсэлт-гуйлт гэсэн бүтэц, зохиомжийн үндсэн хэсгийг бүрдүүлжээ.

НОМ ЗҮЙ

Бямбадорж, 2002: *Бямбадорж Д. Буддын шашны нөлөө монголчуудын галын тахилгад туссан нь / МУИС-ын Эрдэм шинжилгээний бичиг, № 187(13)/*, 121–126 тал. Уб., 2002.

Дулам, 2020: Дулам С. Монгол бэлгэдэл зүй, Өнгийн бэлгэдэл зүй, Зүг чигийн бэлгэдэл зүй, II дэвтэр, */Монгол соёлын чуулган-VII/*. Уб., 2020.

Дулам, Нандинбилиг, 2022: Дулам С., Нандинбилиг Г. Монгол аман зохиолын онол, боть-I, Аман яруу найраг, */Монгол соёлын чуулган-IV/*. Уб., 2022.

Жамбалдорж, 2019: *Жамбалдорж С. Тэмээ тэнгэрийн амьтан*. Уб., 2019.

МАБӨА, 2020: Монгол аман билиг Өмнөговь аймаг. Эмхэтгэн боловсруулсан А. Алимаа, Ч. Заяасүрэн нар. Уб., 2020.

МСМУД, 2021: Монгол сацал, мялаалгын үгийн дээжис. Эмхэтгэн боловсруулсан Ч. Заяасүрэн. Уб., 2021.

Цолоо, 1998: *Цолоо Ж. Тэмээний хишгийн судар // Улаанбаатар таймс сонин, № 174, 175 (1602, 1603) 12 тал*. Уб., 1998.

Чойжилсүрэн, 1964: *Чойжилсүрэн Д. Шувууны даллагын тухай // Монголын судлалын зарим асуудал, Том IV, fasc. 19. 201–214 тал*. Уб., 1964.

TWO OF THE MANUSCRIPT SUTRA'S FOR CAMEL “DALLAGA”

Chuluun ZAYASÜREN

Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

From the imagery of the *Camel Blessing Sutra* (Temegen-ü dalalyiin sudar), it can be seen that for the Mongolians it symbolizes overcoming the three harsh spring months and welcoming the warmth of the new season. It conveys the invocation of fertility, prosperity, the well-being of livestock without loss of mothers or offspring, and the full growth of the herds. This reflects the nomadic herders' worldview in which their perception of nature, harmonious relationships, and imaginative thought have always held an important place in their spiritual life. The abundance of dairy and food, together with the mental and emotional well-being of both people and animals, symbolize the hope for a prosperous summer. By entrusting their wishes to the Eternal Blue Sky, the Golden Earth, and the deities of mountains and waters, Mongolians have, for generations, expressed their desire to live in abundance and well-being. This demonstrates that the deep aspiration for prosperity has long been embedded in the consciousness of Mongolian people. Such a unique characteristic of Mongolian thought — approaching all matters with faith and reverence — has been preserved even in today's era of globalization. The ritual of receiving the *Camel Blessing* has been passed down through generations, incorporating elements of shamanism, Buddhism, and broader Eastern cultural influences. As a result, its imagery has become more enriched, while the main structural components — offering and sacrifice on the one hand, and supplication and petition on the other — have formed its essential composition.

Key words: manuscript sutra, camel Blessing (dalalya), fire sacrifice camel legend, Eternal Blue Sky, the character, composition.

About the author: **Chuluun ZAYASÜREN**, PhD, Associate Professor, Senior Researcher, Department of the Folklore studies, Institute of Language and Literature, Mongolian Academy of Sciences, Deputy Editor of the Journal of “Folklore studies” (Ulaanbaatar, Mongolia) (zayasurench@mas.ac.mn).

О ДВУХ РУКОПИСЯХ “СУТРЫ ПРИЗЫВАНИЯ БЛАГОПОЛУЧИЯ ВЕРБЛЮДАМ”

Чулууны ЗАЯАСҮРЭН

Институт языка и литературы Академий наук Монголии

В статье сравнивается содержание и образный ряд двух текстов призывания благополучия верблюдам, которые сохранились в рукописных источниках. В наши дни не осталось стариков, которые знали бы, как совершать традиционный обряд принятия призывания благополучия верблюду. Быстрое изменение общественной обстановки из-за ускоренного развития и прогресса приводит к тому, что из памяти людей стираются знания старинных обрядов. Согласно тексту “Сутры призывания благополучия верблюдам” (Temegen-ü dalalyiin sudar) следует, что для монголов очень важно благополучное преодоление трёх суровых весенних месяцев и благоприятное вхождение в новый тёплый летний сезон. Оно несёт в себе призыв к плодородию, процветанию, благополучию скота, без потерь матерей и потомства и к полному росту поголовия стада. Это отражает мировоззрение кочевников-скотоводов, в котором восприятие природы, гармоничные отношения и богатое воображение всегда занимали важное место в их духовной жизни. Изобилие молочных продуктов и продуктов питания, а также душевное и эмоциональное благополучие людей и животных символизируют надежду на благополучное лето. Возлагая свои пожелания на Вечное Синее Небо и Златопочвенную Землю, на божества гор и вод, монголы на протяжении поколений выражали своё стремление жить в достатке и благополучии. Это свидетельствует о том, что глубокое стремление к процветанию издавна заложено в сознании монгольского народа. Эта уникальная черта монгольского мышления-подход ко всему с верой и благоговением-сохранилась и в современную эпоху глобализации.

Ключевые слова: рукописная сутра, Благословение верблюда (dalalya), легенда о жертвоприношении верблюда, Вечное Синее Небо, персонаж, композиция.

Об авторе: Чулууны ЗАЯАСҮРЭН, доктор наук, доцент, старший научный сотрудник отдела исследований фольклора, Институт языка и литературы МАН; заместитель главного редактора журнала «Фольклорные исследования» (Монголия, Улан-Батор) (zayasurench@mas.ac.mn).